

ҮНДЭСНИЙ СПОРТЫН VI ИХ НААДАМД ОРОЛЦСОН ТАЙЛАН

2018.08.27.

Арвайхээр

Засгийн газрын 2017 оны 269 дүгээр тогтоолын дагуу Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээн 08 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд Хүй долоон худагт спортын 10 төрлөөр зохион байгуулагдаж, 21 аймаг, 9 дүүргийн 2000 тамирчин оролцлоо.

Тус наадамд Өвөрхангай аймгаас Үндэсний бөхийн барилдаанд 3, үндэсний сур, урианхай, буриад, уламжлалт харваанд 32 харваач, шагайн харваанд 9, ширээний шагайнд 4, уран уурагч, бугуйлч, эмнэг булгиулагч, жороо моринд 4 тамирчин, нийт 52 тамирчин оролцож нийтийн монгол бөхийн барилдаанд Бүрд сумын харьяат М.Батмэнд 1-р байр, аймгийн хүчтэнүүдийн барилдаанд Хархорин сумын харьяат О.Наранбаатар 5-р байр, сумын хүчтэнд Хужирт сумын харьяат Ч.Бямбадорж 10-р байр, багийн дүнгээр 6-р байр,

Уран уурагчийн төрөлд Бүрд сумын харьяат спортын мастер Д.Охинтогтох 1-р байр, бугуйлчийн төрөлд Гучин-Ус сумын харьяат Б.Мягмарсүрэн 4-р байр, багийн дүнгээр 5-р байр,

Ширээний шагайн ганцаарчилсан төрөлд Төгрөг сумын харьяат Т.Отгонсүрэн 2-р байр, Санжаасүрэн 5-р байр, Г.Лхамсүрэн 11-р байр, багийн дүнгээр 10-р байр,

М.Батлут тэргүүлэгчтэй аймгийн Үндэсний сурын холбооны харваачид амжилттай харваж Үндэсний сур харваанд 7-р байр, Уранхай харваанд 6-р байр, Уламжлалт харваанд 6-р байр,

Улсын мэргэн Т.Баярбат ахлагчтай шагайн харваан баг 7-р байр,

Жороо морины уралдаанд 5-р байр

Өвлийн спортын төрөл болох мөсний шагай, мөсний сур харваанд амжилттай оролцсон.

Өвөл, зуны спортын төрлүүдэд амжилттай оролцож 30 байгууллагаас 4-р байр эзлэж өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнагдлаа.



Нийтийн монгол бөх



Уран уургач



Ширээний шагай



Шагайн харваа



Үндэсний сур



Ширээний шагай



Уран уургач, бугуйлч,
эмнэг булгиулагч

